

10 October 2022

On this date I, Erik Versavel, would like to report in respect of my activities and roles related to XAC Bank (XB) for the reporting period 3Q2022.

In the beginning of this reporting period, I conducted in depth interviews with all members of XB's Governance, Nomination and Compensation Committee (GNCC) who recommended my appointment as Independent Non-Executive Director (INED) of XB in its meeting on 21 September 2022.

I attended this meeting as observer having signed a non-disclosure agreement. During this meeting, GNCC Chair Michael Madden asked XB's General Counsel/Corporate Secretary (GC/CS), to present that the GNCC of the Bank recommended to nominate me as INED at XB. The meeting was informed that the GC/CS had submitted all my personal documents and qualifications to the Bank of Mongolia and received a no objection letter on 5 September 2022. GNCC was informed that as per the laws and regulations, directors must be elected at the shareholders meeting. Up until the next shareholders meeting, however, the bank board could appoint me as an interim director. The Chair added that the resolution would be presented to the XB Board Meeting to be held the next day on 22 September and opened the floor for questions and comments. There were no questions or comments.

Also, again in the capacity of observer, I attended the meeting of XB's Audit Committee (BAC) on 21 September 2022.

On 22 September 2022, I attended the XB Board Meeting. For the first 2 agenda items I attended as observer. For the third agenda item 'Reports of the Committees' the Chair of the GNCC recommended to nominate me as INED at XB pursuant to its online voting meeting held on 15-16 June 2022. Mr. Michael Madden asked if there were any comments and questions from the Directors. Since there had been no comments or questions, the Chair of GNCC asked the Board Directors to confirm my interim appointment to the Board as INED. The Chair of the GNCC noted that the GNCC recommended to nominate me. On that basis, my interim appointment to the Board as INED was confirmed with a unanimous vote.

It was further clarified that all requirements and responsibilities were applicable to me as of the date of my interim appointment and that I would need to vote and express independent views and opinions accordingly. I understood that even in interim capacity, my role and duties are guided by the following laws and regulations:

- the Company Law of Mongolia,
- the Banking Law of Mongolia,
- the "Corporate Governance Principles of the Bank" issued by the BoM,
- the "Procedure on Independent director of a bank" issued by Financial Stability Counsel,
- the Charter of Xacbank

- and bylaw regulation documents.


In addition, as per Article 79.3 of the Company Law, an independent member of the Board of Directors shall have the following additional obligations in addition to the rights and obligations of the other members:

- 79.3.1. monitor whether the activities, policies and decision of the Board of Directors and of the executive body negatively affects the interests of the company, whether the activities are in compliance with the laws, rules and procedures, prevent from violations or conflicts, demand from the relevant person to eliminate any violations, if such demand is not complied with, to submit such matter for consideration by the Board of Directors and consequently, to submit the demand to convene a shareholders meeting;
- 79.3.2. to guide the executive body in respect of maintaining the transparency and accessibility of the company's activities, monitor and make demands in respect thereof;
- 79.3.3. to take part in the shareholder's meetings in person, and to inform of any different views taken in respect of the decision rendered by the Board of Directors, respond to questions by the shareholders and to make clarifications.

From then on, I attended the Board Meeting and noted the sequence of agenda items, discussion and voting where applicable, conscious at all times that my every vote was made with consideration of all stakeholders, regulatory requirements and in line with XB's internal and procedures.

Continuation of reports of committees did not bring any additional issues or complexity to the table and all issues were resolved and voted in accordance with the committee discussions and voted upon anonymously.

I appreciated the candid update by the CEO of XB in respect of the Banking Sector update with specific focus on the NPL situation, noting that XB's numbers are best in class in this area, thanks to a long-standing prudent risk management approach and prudential guidance by the Board. The liquidity situation in the banking system and pressure on the currency were also discussed at length. Strong performance of XB was discussed and the management commended for these results. My independent view is that this is indeed a remarkable achievement and of critical importance considering the challenges in the local market, and the external pressures on the country. I also welcomed the Chairman's historic context which focused on the strategic decisions of asset growth and who cautioned for diverting from this path at these difficult times.


Erik Versavel
Interim Independent Non-Executive Director Xac Bank
Colombo
Sri Lanka
10 October 2022

2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

Эрик Версавел, миний бие энэ өдөр ХасБанк (ХБ) – тай холбоотой ажлын тайланг 2022 оны 3 дугаар улирлын байдлаар гаргаж байна.

Тайлант хугацааны эхэнд миний бие ХБ-ны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр нэр дэвшин ХБ-ны ТУЗ-ийн Цалин урамшуулал, нэр дэвших хорооны (ЦУНДШХ) бүх гишүүдтэй ярилцлагад оролцож 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн хурлаар ХБ-ны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдохоор нэр дэвшигдсэн болно.

Миний бие тухайн өдрийн хуралд Нууц хадгалах гэрээ байгуулан ажиглагчаар оролцов. Хурлын үеэр ЦУНДШХорооны дарга Майкл Мадден ХБ-ны ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ХБ-ны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр нэр дэвшүүлж байгаа нэр дэвшигчийг танилцуулахыг хүсэв. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нэр дэвшигчийн хувийн материалыг МонголБанкинд хүргүүлж 2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр хараат бус гишүүнээр томилоход татгалзах зүйлгүй гэсэн хариуг албан ёсоор авсныг мэдэгдэв. Хорооны хурлын үеэр ТУЗ-ийн жинхэнэ гишүүн болон хараат бус гишүүн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилогддог хууль эрх зүйн зохицуулалттай болохыг танилцуулав. Дараагийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл Банкны ТУЗ нэр дэвшигчийг түр томилох эрхтэй. Хурал даргалагч 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр хуралдах ХБ-ны ТУЗ-ийн хуралд тогтоолын төсөл танилцуулах болсныг хэлээд асуулт, тодруулах зүйл байгаа эсэхийг лавлан асуув. Гишүүдээс асуулт, тодруулах зүйл байгаагүй болно.

Мөн, ажиглагч байдлаар миний бие 2022 оны 9 дүгээр сарын 21-нд хуралдсан ХБ-ны Аудитын хорооны хуралд оролцов.

Миний бие 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр ХБ-ны ТУЗ-ийн хуралд оролцов. Хурлаар хэлэлцэх эхний 2 асуудалд миний бие ажиглагчаар оролцсон. Хурлын гурав дахь асуудал “Хороодын тайлан” байсан ба ЦУНДШХорооны дарга 2022 оны 6 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд явагдсан цахим санал хураалтаар ХБ-ны ТУЗ-ийн хараат бус гишүүнд миний нэрийг дэвшүүлэх болсныг танилцуулав. ТУЗ-ийн гишүүдээс асууж, тодруулах зүйл байгаа эсэхийг Хорооны дарга Майк Мадден асуув. Гишүүдээс тодруулах зүйл нэгэнт байгаагүй тул ЦУНДШХорооны дарга ТУЗ-ийн хараат бус гишүүнээр миний нэрийг дэвшүүлж түр томилж батлахыг ТУЗ-ын гишүүдэд уламжлав. Миний бие ХБ-ны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр санал нэгтгэйгээр түр томилогдсон болно.

Түр томилогдсон цагаас эхлэн бүх шаардлага, үүрэг хариуцлага үүсэж байгааг ухамсарлаж бие даасан, хараат бус үзэл бодол, санал илэрхийлж санал хураалтад оролцох ёстойг ойлгов. Түр томилогдсон ч гэлээ дараах хууль, тогтоомжийг баримтлан ажил үүргээ гүйцэтгэнэ:

- Монгол Улсын Компанийн тухай хууль
- Монгол Улсын Банкны тухай хууль
- Монголбанкнаас баталсан “Банкны зохистой засаглалын журам”
- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”
- ХасБанкны Компанийн дүрэм
- Бусад хууль эрх зүйн актууд.

Компанийн тухай хуулийн 79.3 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүн дараах нэмэлт үүрэг хүлээхийг заасан:

- 79.3.1.төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;
- 79.3.2.компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
- 79.3.3.хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.

Томилогдсон цагаас хойш миний бие ТУЗ-ийн хуралд бүрэн оролцож хөтөлбөрт тусгасан асуудал болгоны хэлэлцүүлэг, санал хуралтад оролцохдоо оролцогч талуудын ашиг сонирхол, ХБ-ны дотоод үйл ажиллагааны дүрэм журамд заасан шаардлага, хэм хэмжээг баримтлан ухамсартайгаар оролцов.

Хороодын тайланг танилцуулах явцад ямар нэгэн нэмэлт асуулт, хариулт явагдаагүй бөгөөд бүх асуудлуудыг хорооны үйл ажиллагааны журмын дагуу хэлэлцэж баталсан болно.

ХБ-ны Гүйцэтгэх захирал банкны салбар, тэр дундаа чанаргүй зээлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгч байсныг миний бие өндрөөр үнэлснийг үүгээр уламжилж байна. Тэрээр, банкны баттай суурь болон эрсдэлийн зөв, урт хугацааны удирдлагын ачаар сайн үзүүлэлттэй гарсныг ч уламжилсан болно. Үүнээс гадна, банкны системд ирж байгаа валютын дарамтын тухай ч дэлгэрэнгүй хэлэлцэв. ХБ өндөр үр өгөөжтэй ажилласныг онцлоод удирдлагын багийн хөдөлмөрийг өндрөөр үнэлэв. Миний зүгээс бие даасан үнэлэлт өгөх ёстой ба энэ хүрээнд банкны хамт олон тодорхой амжилтад хүрч чадсан, түүнчлэн одоогийн зах зээлийн нөхцөл байдал, улс оронд ирж байгаа дарамтыг тооцоолж үзвэл том алхам хэмээн дүгнэв. Мөн, миний бие энэ хүнд хэцүү цагт замаасаа хазайлгүй стратегийн зөв шийдвэр гаргаж активын өсөлт хийж чадсан ТУЗ-ийн Даргад талархлаа уламжлав.

Эрик Версавел

Түр томилогдсон ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн

Коломбо

Шри-Ланка

2022 оны 10 дугаар сарын 10